



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/402

Улаанбаатар хот

Газар эзэмшүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 21.5.4 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын “Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг баталсан 2025 оны 120 дугаар тогтоол нийслэлийн Засаг даргын 2025 оны эрх шилжүүлэх тухай А/715 дугаар захирамж, Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө баталсан 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар дээрээ олон жил амьдарч байгаа холбогдох журамд нийцсэн иргэдээсирүүлсэн хүсэлтийн дагуу хавсралтад дурдсан нэр бүхий 126 (Нэг зуун хорин зургаа) иргэнд газар эзэмшүүлэх эрх олгосугай.

2.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгож хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Н.Насанбуян)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ